

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202212221

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Баргилт (ХV-021822) Жоншны ордод хайгуулын өрөмдлөг хийх, үр дүнгээр нөөцийн тодотгол тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших ХV-021822 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд геологи хайгуулын өрөмдлөг хийх, үр дүнгээр нөөцийн тодотгол тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын харъяа “Бор-Өндөр” УБҮ-ийн жоншны нөөцийг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
  - Байгууллагын ерөнхий танилцуулга
  - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
  - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
  - Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсхүл гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт.
4. Сонирхсон этгээд мэдүүлгээ 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 09:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.
5. Тендерийг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 09:10 цагт цахимаар нээнэ.

**“Монголросцветмет” ТӨҮГ**

**Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002**

**Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.**

**22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 508 тоот,**

**И-мейл: [mailbox@monros.mn](mailto:mailbox@monros.mn).**

**Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-450060-186**